



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 489

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Швейцарын Холбооны Улс дахь Монгол Улсын Элчин сайдын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, нийт 98,001.99 (ерэн найман мянга нэг ам.доллар ерэн есөн цент) ам.долларын балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, Швейцарын Холбооны Улс дахь Монгол Улсын Элчин сайд Л.Пүрэвсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэг, материал болгон ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн  
189 дугаар тогтоолын хавсралт

ШВЕЙЦАРЫН ХОЛБООНЫ УЛС ДАХЬ МОНГОЛ УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМНЫ ҮНДСЭН  
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (ам.доллар)	Балансын үнэ (ам.доллар)	Хуримтлагдсан элэгдэл (ам.доллар)	Үлдэгдэл өртөг (ам.доллар)
1	Байршил тогтоогч /Navigation GPS/	2010.01.01	1	184,94	184,94	184,94	-
2	Машин Volvo S40 1.8 арал- YV1MS214272291401	2006.01.01	1	22 586,47	22 586,47	22 586,47	-
3	Машин Volkswagen Caravelle CD GE 488, арал- WV2ZZZZ7HZZ8HO37396	2009.01.02	1	36 630,00	36 630,00	36 630,00	-
4	Өвс хадагч машин	1998.01.01	1	279,00	279,00	279,00	-
5	Гагнуурын аппарат	1985.01.01	1	151,14	151,14	151,14	-
6	Гал тогооны сав суулга угаагч	2009.01.01	1	510,00	510,00	510,00	-
7	Зууш бэлтгэгч машин Primodesq	2010.01.01	1	18,29	18,29	18,29	-
8	Мод тайрагч цахилгаан хөрөө	2004.01.01	1	250,61	250,61	250,61	-
9	Цахилгаан өрөм "Bosch"	1987.01.01	1	155,32	155,32	155,32	-
10	Цахилгаан зуух суурилуулах	2009.01.01	8	4 641,60	37 132,80	37 132,80	-
11	Шохой шуршигч	2010.01.01	1	103,42	103,42	103,42	-
	<b>Нийт дүн</b>	-	<b>18</b>	<b>65510,79</b> (жаран таван мянган таван зуун арван ам.доллар далан есөн цент)	<b>98001,99</b> (ерэн найман мянга нэг ам.доллар ерэн есөн цент)	<b>98001,99</b> (ерэн найман мянга нэг ам.доллар ерэн есөн цент)	-